



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 27 өдөр

Дугаар 0/398

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Аварга тосон рашаан сувилал" ХХК нэхэмжлэл гаргасантай холбогдуулан Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.3, 20.1.4, 20.1.5, 20.1.6, 20.1.7, 20.2.1, 20.2.2, 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.6, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.2.1 дэх заалтуудад заасан бүрэн эрхийг Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн (Д.Мягмарбаатар), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын Газрын удирдлагын хэлтсийн дарга (Ц.Билэгсайхан) нарыг аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр (хэрэг хянан шийдвэрлэх хугацаагаар) томилсугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 23-ны А/277 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хариуцагчийг бүрэн төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн (Д.Мягмарбаатар), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын Газрын удирдлагын хэлтсийн дарга (Ц.Билэгсайхан) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ